



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 88

Мандалговь

**Төрийн өмчөөс орон нутгийн өмчид хөрөнгө  
бүртгэж авах тухай**

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дах хэсгийн 77.2.3 дахь заалт, 77.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2018 оны “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” 61 дүгээр тогтоол аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Дорнод аймгийн Хөдөлмөрийн хэлтэсд ашиглаж байсан 20,990,200 /хорин сая есөн зуун ерэн мянга хоёр зуун/ төгрөгний балансын үнэтэй, 8,162,855,57 /найман сая нэг зуун жаран хоёр мянга найман зуун тавин таван төгрөг тавин долоон/ мөнгөнийүлдэгдэл өртөгтэй Лексус 470 маркын автомашиныг Орон нутгийн өмчийн газарт бүртгэсүгэй.

Хоёр: Хөрөнгө хүлээлцэх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу ажлын хэсэг томилон зохион байгуулахыг Аймгийн Засаг даргад даалгасугай.

2.1.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх:

2.2.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

